

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

(2015 оны 3 дугаар улирлын байдлаар)

Монголбанкны Хяналт шалгалтын газраас 2015 оны 3 дугаар улиралд хийж гүйцэтгэсэн ажлын ерөнхий мэдээллийг танилцуулж байна.

- Тайлант улиралд 2 банкны зээлийн чанар, 40 том зээлийн хувийн хэрэг болон эх үүсвэрийн үлдэгдлүүдэд хэсэгчилсэн шалгалт хийж дууссан болно. Хэсэгчилсэн шалгалтаар эдгээр банкуудад, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу зээлийн ангиллыг тогтмол хийж, зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулах, хуримтлуулж тооцсон зээлийн хүүг тэнцлийн гадуур бүртгэж байхыг үүрэг болгож, холбогдох журмын дагуу Улсын байцаагчийн акт тогтоож, мэдэгдэл хүргүүлэх зэрэг арга хэмжээг авсан.
- Мөн 3 банкинд газар дээрх иж бүрэн шалгалтыг хийж байга бөгөөд шалгалтаар холбогдох журмын дагуу зээлийн ангиллыг хийж, зээлийн эрсдэлийн санг байгуулдаггүй, хуримтлуулж тооцсон хүүг тэнцлийн гадуур гарган бүртгэдэггүй, зарим банкуудын хувьд Монголбанкнаас өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, зээл төлүүлэх талаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийг зөрчсөн зэрэг дутагдлууд илэрлээ. Дээрх банкуудад хийсэн дүнг удахгүй Хяналт шалгалтын зөвлөлөөр хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргуулан, биелэлтэнд нь хяналт тавин ажиллах болно.
- Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд шинээр батлагдсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, тайлант улиралд “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам” болон “Банкны зохистой засаглалыг үнэлэх аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд үүнтэй холбогдуулан “Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-д хараат бус гишүүнийг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилж, Монголбанкны зөвшөөрлөөр үүрэгт ажлаас нь чөлөөлөх, системийн нөлөө бүхий банкууд компанийн хэлбэрээс үл хамааран ТУЗ-ийн Хараат бус гишүүн 3 буюу түүнээс дээш байхаар тус тус тусгасан бөгөөд тушаалын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.
- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банкуудад өгсөн үүрэг даалгавар болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудад зайнаас хяналт тавих ажлыг хэрэгжүүлж, банкуудаас сар бүр ирүүлсэн санхүүгийн тайлан мэдээг хянан шалгаж, тохируулгын гүйлгээ хийх шаардлагатай банкны тэнцэлд гүйлгээг хийж, тайлангийн хариуг сар бүр хүргүүлж байна.
- Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2015 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн А35/20 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А-57 тоот тушаалаар шинэчлэн тогтоосон “Зөвшөөрөл олгох үйлчилгээний шимтгэлийн нөхцөл”-ийг цахим хуудсанд байршуулсан болно.

- Банкуудын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналт шалгалтын хүрээнд банкуудын санхүү, төлбөрийн чадварын талаарх санхүүгийн ерөнхий дүгнэлт, мэдээллийг боловсруулж, банкуудаас ирүүлсэн тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг, материалыг хууль, журам, зааврын дагуу шалгаж удирдлагад танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулах, банкинд хийх хяналт шалгалтыг хугацаанд нь чанартай, тогтмол, үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын судалгаа, Банкны тухай хуулийн 38.2 дугаар заалтын биелэлт, салбар нэгжийн өөрчлөлтийн судалгааг боловсруулж удирдлагуудад танилцуулж шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.
- Банкны системийн нэгдсэн тайлан тэнцэлд үндэслэн судалгаа шинжилгээг тогтмол хийж, хяналт шалгалтын чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон ажиллаж байна.
- Тайлант улиралд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А-151 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-д заасан Банкны зохистой засаглалыг үнэлэх аргачлалын дагуу бүх банкуудаас зохистой засаглалын үнэлгээний тайланг хүлээн авч, хариуцсан хянан шалгагчаар дахин үнэлүүлж, журамд заасан хугацаанд хариуг хүргүүлж ажиллалаа.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР